



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Аймгийн ИТХ-ын захиалга, Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн,
ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн
аудитын тайлан

“МАЛ ЭМНЭЛГИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ”

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг батлагдсан төсөв,
төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, халдварт өвчлөлийн тоо буурч байгаа ч
урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг бууруулж, хамрагдах малын тоог
багасгаж байгаа нь өвчлөл нэмэгдэх эрсдэлийг дагуулж байна.

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын харьяа
Сэлэнгэ аймгийн
Аудитын газар

Тэргүүлэх аудитор
Ч.Энхтуяа

Аудитын менежер
Б.Батмөнх

Аудитор
Б.Эрдэнэзул
Шинжээч
А.Дашбат

2016 оны 11 сар

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70363036 дугаарын утас, 70363040 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ: Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум, аймгийн ЗДТГ-ын байрны өргөтгөлд

Товчилсон үгийн жагсаалт 2

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 3

Бүлэг 1. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг хууль, журмын дагуу үндэслэлтэй төлөвлөж байна уу?

1.1 Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг тооцоо судалгаан дээр үндэслэн төлөвлөж, батлуулж байна уу?

1.2 Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг бодитой хуваарилж байна уу?

Бүлэг 2. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулж байгаа эсэх?

2.1 Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын санхүүжилт цаг хугацаандаа бүрэн олгогдож байна уу?

2.2 Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулж байна уу?

2.3 Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг үнэн зөв бүртгэж, тайлагнаж байна уу?

Бүлэг 3. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?

3.1 Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?

3.2 Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тавих дотоод хяналт үр дүнтэй байна уу?

Аудитын дүгнэлт

Илрүүлсэн зөрчил

Зөвлөмж

Холбогдох байгууллагын санал:

ХХААГ-аас ирүүлсэн санал

Саналд өгсөн тайлбар

Хавсралтууд

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид
ҮАГ	Үндэсний аудитын газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХХААЖДҮГ	Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХААЯ	Хүнс, хөдөө аж ахуйн яам
МЭҮН	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ХААТ	Хөдөө аж ахуйн тасаг
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
МЭУСАХЗ	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал
ДХХ	Дотрын халдварт хордлого
ГЦХИБ	Гахайн цусан халдварт иж балнад

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. 1. Аудит хийсэн үндэслэл

Аудитыг аймгийн ИТХ-ын захиалга, Сэлэнгэ аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвөгөөг үндэслэн Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүн, үр нөлөөт байдлыг шалган дүгнэлт, зөвлөмж өгч, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд гүйцэтгэлийн аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

1. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг хууль, журмын дагуу үндэслэлтэй төлөвлөж байна уу?
2. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулж байгаа эсэх?
3. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?

Аудитад аймгийн ЗДТГ, ХХААГ, 17 сумын Хөдөө аж ахуйн тасгийн дарга мэргэжилтнүүд, МХГ-ын байцаагч нар болон 43 МЭҮН-ийг хамруулав.

1.3 Аудитын арга зүй:

Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан анхан шатны баримт, журналтай тулгах, дүн шинжилгээ хийх, холбогдох ажилтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, судлах, харьцуулалт хийх, тулган баталгаажуулах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр нотлох зүйл цуглуулан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа

Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ТБОНӨХБАҮХАТухай хууль, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2008 оны 305 дугаар тогтоолоор батлагдсан *“Малын гоц халдварт өвчний оношийг баталгаажуулах, хорио цээр, хязгаарлалтын бүс тогтоох, уг бүсэд үйл ажиллагаа явуулах журам”*, Засгийн газрын 2011 оны 247 дугаар тогтоолоор батлагдсан *“Шүлхий өвчнөөр эрүүл, вакцин хэрэглэдэггүй бүс, завсарын бүс, шүлхий өвчнөөр тайван, вакцин хэрэглэдэг бүс тогтоох, уг бүсүүдэд мэл эмнэлэг, хорио цээрийн үйл ажиллагаа явуулах журам”* болон аймгийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, ХХААГ-ын даргын тушаал зэргийг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Аудитыг Сэлэнгэ аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн, аудитор Б.Эрдэнэзул, шинжээч А.Дашбат нар 2016 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 01-ний хооронд хийж гүйцэтгэв.

Бүлэг 1

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг хууль, журмын дагуу үндэслэлтэй төлөвлөж байна уу?

МЭҮН, ХХААГ-аас халдварт өвчлөлийн эпизоотологийн зураглал, өвчлөлийн бүртгэл зэргийг үндэслэн эрсдэлтэй бүх мал сүргийг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулахаар тооцож төсвийн төсөл хүргүүлдэг ч 41 хүртэлх хувиар хасагдан батлагдаж байна.


1.1 Мал эмнэлэгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах төсвийн саналыг хүргүүлсэн хэмжээнээс 32.7-41.3 хувиар бууруулан баталж байна.

Аймгийн ХХААГ-ын Мал эмнэлгийн хэлтэс нь Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д “энэ хуулийн 15.1.2-т заасан өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлоход шаардагдах үйлчилгээний хөлсийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасны дагуу вакцинжуулалтад хамрагдах мал, амьтны тоо, тэдгээрт шаардагдах вакцины захиалгыг улсын Мал эмнэлгийн үржлийн газраар жил бүр хянуулж, үйлчилгээний хөлсийг орон нутгийн төсвөөс олгохоор төлөвлөн батлуулж ирсэн байна.

Малын урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг хуваарилах тогтоосон заавар, журам байдаггүй бөгөөд мал эмнэлгийн анхан шатны нэгжээс өвчлөл гарах эрсдэл бүхий малын тоог гарган аймгийн ХХААГ-т хянуулан, нэгтгэж УМЭҮГ-т хүргүүлдэг байна.

Гэвч Сэлэнгэ аймагт өвчлөл бага гардаг гэсэн шалтгаанаар сүүлийн жилүүдэд хүргүүлж буй төсвийн саналыг 32.7-41.3 хувиар бууруулан баталж иржээ.

МЭҮН-үүдээс 2011-2015 оны ирүүлсэн төсвийн саналыг батлагдсан төсөвтэй нь харьцуулж графикаар харуулбал: /сая төгрөг/



Графикаас харахад 2012 онд МЭҮН-үүдээс ирүүлсэн төсвийн саналыг 144.3 сая төгрөгөөр нэмэн баталж байсан бол 2013-2015 онд 265.6-385.5 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

Аймгийн ИТХТ-ийн 2012 оны 21-р тогтоолоор “Төрөөс зардлыг хариуцах мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний хөлсний жишиг үнэлгээ”-г шинэчлэн баталж, үйлчилгээний үнэ тарифыг 3.3-4.5 дахин нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор хүргүүлсэн төсвийн саналыг нэмж баталсан байна.

Харин 2013 оноос эхлэн аймгийн хэмжээнд эпизоотологийн зураглалд бүртгэгдсэн халдварт өвчний тоо буурч байгааг үндэслэн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах малын захиалгын тоог 497.8-665.5 мянган толгойгоор, төсвийн саналыг 265.6-385.5 сая төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

1.2 Батлагдсан төсвийг МЭҮН-дэд хуваарилах тогтоосон заавар, аргачлал байдаггүйгээс малын тоо, халдварт өвчлөлийн эпизоотологийн зураглал зэргийг үндэслэн хуваарилж байна.

Аймгийн ИТХ-ын 2014 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 56 дугаар тогтоолоор 2015 оны МЭУСАХЗардлыг 547,747.0 мянган төгрөгөөр баталсны дагуу аймгийн ХХААГ-аас МЭҮН-үүдэд олгох төсвийн хуваарийг халдварт өвчний эпизоотологийн зураглал, харьяа малын тоо зэргийг харгалзан тооцоолж, газрын даргаар батлуулан мөрджээ.

Хэдийгээр батлагдсан төсөвт тааруулан хуваарилалтыг хийж байгаа ч МЭҮН-үүдэд төсөв хэрхэн хуваарилсан нарийн тооцоолол байхгүй, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах мал, амьтны тоог хэрхэн сонгож байгаа нь тодорхойгүй байна. Аудитын явцад нохойд хийх галзуу, бог малд хийх боом, гахайд хийх мялзангийн вакциныг хэрхэн хуваарилсныг дахин тооцоолол хийж үзэхэд дараах зөрчил, дутагдал илэрлээ. Үүнд:

- ✓ МЭҮН-үүдийн айл өрхүүдтэй хийсэн гэрээнд тусгасан вакцинд хамрах малын тоог үндэслэн төсөв хуваарилдаг гэж байгаа ч хуваарилсан санхүүжилт, гэрээ хийсэн өрхүүдийн малын тоо нь хоорондоо уялдаагүй, өөрөөр хэлбэл айл өрхийн бүртгэлд байхгүй мал амьтанд вакцин хийхээр тооцоолсон, айл өрхүүдтэй хийсэн гэрээнд тусгагдсан мал, амьтнаас илүү тоогоор вакцин хийхээр хуваарилсан байна. Тухайлбал Сэлэнгэ гранд МЭҮН-ийн гэрээнд үхэр байхгүй боловч 4000 үхэрт боомын вакцин хийсэн, 18 МЭҮН-ийн өрхийн бүртгэлд гахай байхгүй боловч гүйцэтгэлээр 200-1300 гахайг мялзангийн вакцинд хамруулсан, 23 МЭҮН-ийн өрхийн бүртгэлд нохой байхгүй боловч 100-800 нохойг галзуугийн вакцинд хамруулсан гэх мэтээр уялдаа холбоогүй байв.
- ✓ 2014 онд гахайн мялзан өвчин гарсан, өвчлөлтийн эрсдэлтэй Баянгол суманд 1000 толгой гахайг вакцинд хамруулахаар төлөвлөсөн ч уг өвчин гараагүй Цагаануур, Хүдэр, Сүхбаатар, Мандал сумдад ойролцоогоор 1000-1700 гахайг хамруулахаар төлөвлөсөн байна. /Хавсралт 1/.

Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2-т “мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээ хийлгэх, үйлчлүүлэх албаа сонгох эрхтэй” гэж заасны дагуу иргэн, хуулийн этгээд нь өөрсдөө МЭҮН-ээ сонгон үйлчлүүлдгээс жил бүрийн МЭҮН-ийн хариуцах малын тоо өөрчлөгдсөн нь төсвийн хуваарилалт харилцан адилгүй хийгдэхэд нөлөөлсөн байна.

МЭҮН-үүдийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах мал, амьтны тоог хуваарилсан төсөвтэй нь сүүлийн 3 жилээр харьцуулж харуулбал:

Хүснэгт 1. / мян төг /

№	Сумдын нэр	МЭҮН-ийн нэр	2013 он		2014 он		2015 он	
			Малын тоо	Төсөв	Малын тоо	Төсөв	Малын тоо	Төсөв
1	Алтанбулаг	Бөхлөө хангай	19921	11,105.2	25645	15,371.2	24306	13,681.5
		Бумбат өлгий	19309	10,807.2	22000	13,505.0	17596	9,824.0
2	Ерөө	Лхачинбу	35526	17,966.5	31809	17,952.3	30902	15,880.5
		Бадаан зүрх	11454	5,643.5	7700	4,030.0	10600	5,500.0
3	Зүүнбүрэн	Энхбүрэн сүрэг	25129	13,112.3	25900	13,890.0	27096	14,499.0
		Оюут сүрэг	38471	20,472.7	44560	24,550.0	37893	20,643.2
4	Мандал	Тавансуварга	27077	14,169.3	30400	17,345.0	19695	10,803.8
		Сэр эрдэнэ оюухай	14440	7,445.0	19300	10,845.0	19330	10,452.5
		Дөлгөөн хараа	14966	7,796.5	14400	8,305.0	15355	8,428.7
		Нарны сүрэг	16740	8,750.0	14785	8,451.2	17200	9,715.0
		Хараа түшээ	16077	8,509.2	15886	9,426.5	24930	13,987.5
5	Орхон	Орхонсүрэг	23688	12,367.0	25000	14,010.0	27440	14,875.0
		ЭГДЭМ	38242	20,830.5	38942	21,630.5	37942	21,230.5
6	Сант	Сант баян хайрхан	32820	16,855.0	24749	13,642.3	27616	15,119.0
		Бошгын булаг			13800	6,890.0	22291	11,882.7
7	Цагааннуур	Таван хишиг	40711	20,692.7	26000	13,770.0	28533	15,658.3
		Дэвжих дөл			22300	11,340.0	26170	14,151.5
		Сэлэнгэ буян хишиг	44639	22,719.7	32838	17,544.5	30246	16,012.5
8	Баянгол	Баттарьд	49080	25,340.0	49994	26,292.0	44799	24,059.7
		Мэргэн онош	43022	22,960.5	39796	22,304.0	33344	18,716.0
9	Орхонтуул	Анар уул	49588	24,812.0	31300	17,015.0	33250	18,002.5
		Сүргийн ундраа	47482	23,935.5	31462	16,950.5	27219	14,414.7
		Сэлэнгэ гранд			18500	9,550.0	20588	11,002.0
10	Баруунбүрэн	Бүрэн сүрэг	42191	21,627.5	30100	16,090.0	29422	15,655.5
		Батцэнгүүн	42359	21,754.7	30413	16,153.3	29300	15,625.0
		Баатар түмэн сүрэг			19100	9,710.0	25862	13,660.5
11	Сайхан	Цөм сүрэг	38958	20,819.5	35500	19,075.0	36455	19,353.8
		Хөх сэрхийн өвөр	23262	12,345.5	23309	12,742.2	22051	12,252.7
12	Жавхлант	Буянт таван эрдэнэ	23574	12,468.5	20800	11,530.0	18795	11,343.8
		Ачитулга	24067	12,936.7	21927	12,061.8	22490	12,942.5
		Мөнх сүрэг эрдэнэ	22437	11,994.3	20200	11,350.0	20070	11,232.5
		Сорлог мал	16092	8,813.0	12379	7,334.7	10355	5,943.8
13	Түшиг	Номтын өндөр	17285	9,076.2	10580	5,460.0	12632	7,118.0
		Хонгор овоо	13365	6,911.3	13500	7,060.0	13948	7,752.0
		Мөнх зэлтэр	9350	4,997.5	11405	6,451.3	14145	7,981.2
14	Шаамар	Туяа сан	17949	9,442.2	13120	7,915.0	14653	8,508.3
		Өсөх эрдэнэт сүрэг	21804	11,576.0	19353	11,968.2	16453	9,453.2
		Даншиг халзан	14627	7,551.7	10436	6,139.0	10993	6,283.3
15	Хушаат	Баян ишгэнт	25134	13,693.5	22700	12,810.0	19987	11,666.7
		Эх жишиг	52776	27,239.0	36376	20,089.0	33313	18,373.2
16	Хүдэр	Марс нуга	17400	9,065.0	15150	8,377.5	20119	10,719.8
17	Сүхбаатар	Дампил хайрхан	16560	9,125.0	15980	9,650.0	11314	6,408.5
		Их цагааны рашаан					7830	4,117.5
Аймгийн нөөц						1,150.0		2,795.0
Нийт дүн			1,047,572	547,727.4	989,394	547,727.0	994,528	547,726.9

Хүснэгтээс харахад аймгийн дүнгээр вакцинд хамруулах мал, амьтны тоо 2013 оноос 53,044-58,178 толгойгоор буурсан ч батлагдсан төсвийн дүн буураагүй

байна. Иймээс бид аудитын явцад 2015 оны төсвийг дахин тооцоолж үзэхэд эпизоотологийн зураглал дээр үндэслэн вакцинд хамрагдах мал, амьтны тоо, санхүүжилтийг батлагдсан тарифын дагуу үнэн зөв тооцоолсон болох нь тодорхой байлаа. Өөрөөр хэлбэл, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын үйлчилгээний хөлс бага байдаг бог малын тоо 74,600-206,300 толгойгоор буурч, үйлчилгээний хөлс өндөр тогтоогддог бод малын тоо 5,406-121,900 толгойгоор өссөн нь малын дүн нийт дүнгээр буурсан ч төсвийн дүн ижил батлагдахад нөлөөлсөн байна.

Цаашид аймгийн ХХААГ-аас мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг үнэлж, хуваарилах аргачлалыг боловсруулж мөрдөх шаардлагатай байгаа бөгөөд энэ нь өвчлөл гарах эрсдэл бүхий мал, амьтны тоог бодитой үнэлэх, хуваарилалтыг тодорхой болгох ач холбогдолтой юм.

Бүлэг 2

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулж байгаа эсэх?

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг батлагдсан төсвийн хүрээнд, зориулалтын дагуу зарцуулж байгаа ч анхан шатны баримтын бүрдлийг иж бүрэн хангаагүй ажил гүйлгээг бүртгэлд тусгаж байна.

2.1 МЭҮН-үүдийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын санхүүжилтийг харилцан адилгүй олгож байна.

Аймгийн 2015 оны төсөвт мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр 547,727.0 мянган төгрөгийн зардал батлагдсан ч төсвийн орлого тасарсан /аймгийн урсгал орлого 1.2 тэрбум төгрөгөөр буюу 9.8 хувиар/ шалтгаанаар 333,015.6 мянган төгрөгийн буюу нийт санхүүжилтийн 60.8 хувийг олгожээ.

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын санхүүжилтийг Төрийн сан дахь ХХААГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан 328,570.6 мянган төгрөгийг 43 МЭҮН-ийн харилцах данс руу шилжүүлж, 4,445.0 мянган төгрөгийг татан төвлөрүүлжээ.

Хэдийгээр МЭҮН-үүдийн санхүүжилтийг Сэлэнгэ аймгийн ХХААЖДҮГ-ын даргын 2013 оны 29 дугаар тушаалаар баталсан “Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, шинжилгээ хийсэн үйлчилгээний хөлсийг мал эмнэлгийн нэгжүүдэд олгох журам”-ын дагуу зохих баримт материал бүрдүүлэн, хянуулсны үндсэн дээр олгож байгаа ч **санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэхгүйгээр, харилцан адилгүй** олгож байна.

МЭҮН-үүдэд олгосон санхүүжилтийн дүнгээс харахад 10 МЭҮН-д 34-50 хүртэлх хувийн, 12 МЭҮН-д 50-60 хүртэлх хувийн, 16 МЭҮН-д 60-80 хүртэлх хувийн, 4 МЭҮН-д 80-92 хүртэлх хувийн санхүүжилтийг олгосон байх бөгөөд 1 МЭҮН-д санхүүжилтийг 100 хувь олгосон байна. **IXавсралт 2I.** Тухайлбал:

- ✓ Баянгол сумын “Мэргэн онош” МЭҮН-д 100 хувь,
- ✓ Хушаат сумын “Эх жишиг” МЭҮН-д 92 хувь,
- ✓ Баруунбүрэн сумын “Батцэнгүүн”, “Даншигхалзан”, “Өсөх эрдэнэт сүрэг” 3 МЭҮН-д 80-83 хувийн санхүүжилтийг олгосон бол
- ✓ “Баатартүмэн сүрэг”, “Марснуга”, “Бошгын булаг”, “Орхонсүрэг”, “Хөх сэрхийн өвөр”, “Дэвжих дөл”, “Анар-Уул”, “Нарны сүрэг”, “Сэлэнгэгранд” гэх мэт МЭҮН-д 32.9-47.0 хувийг олгосон байна.

Цаашид аймгийн төсвөөс олгосон санхүүжилтийн хувь хэмжээ, МЭҮН-үүдийн ажлын гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилтийг жигд хуваарилан олгож байх шаардлагатай байна.

2.2 Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг батлагдсан төсвийн дагуу зарцуулсан ч анхан шатны баримтын бүрдлийг иж бүрэн хангахгүй байна.

Аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Сэлэнгэ аймгийн 2015 оны тодотгосон төсөв батлах тухай” 72 дугаар тогтоолоор мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 547,727.0 мянган төгрөгийг зарцуулахаар баталжээ.

Батлагдсан төсвийг үндэслэн аймгийн ХХААГ-аас малын тоо, халдварт өвчний бүртгэл, өвчлөл гарах эрсдэл зэргийг тооцон сумдын МЭҮН-үүдэд дахин төсвийн хуваарилалтыг хийж газрын даргаар батлуулан, сумдын Засаг дарга, МЭҮН-тэй гурвалсан гэрээ байгуулан баталгаажуулдаг байна.

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын санхүүжилтийг олгохдоо аймгийн ХХААЖДҮГ-ын даргын 2013 оны 29 дугаар тушаалаар батлагдсан “Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, шинжилгээ хийсэн үйлчилгээний хөлсийг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд олгох журам”-ын дагуу дараах баримт материалыг үндэслэдэг байна. Үүнд:

- ✓ Сумын Засаг даргын “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг явуулах тухай” захирамж, МЭҮН-д санхүүжилт олгохыг хүссэн албан бичиг;
- ✓ Тухайн МЭҮН-ийн санхүүжилт хүссэн албан бичиг, нэхэмжлэх;
- ✓ МЭҮН-ийн үйлдсэн малд тарилга хийсэн нэгдсэн акт;
- ✓ Мал сүрэгтээ тарилга хийлгүүлсэн малчны өрхийн дэвтрийн дугаар, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан малын тоо, зарцуулсан вакцины тооцоо, малчин өрхийн эзний гарын үсэг зэргийг агуулсан малын тарилга хийсэн цувааны хүснэгт;
- ✓ Шинжилгээнд хамрагдсан цусны дээж авсан бүртгэл цуваа;
- ✓ МЭХ-ийн дарга, халдварт өвчин, эм хангамж хариуцсан мэргэжилтэн, лабораторийн эрхлэгч, ийлдэс судлаач, нян судлаач, ариутгал халдваргүйтэл хариуцсан эмч, параазиттах өвчин хариуцсан эмч, нягтлан бодогч нарын 6 хүний гарын үсгээр баталгаажсан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хийсэн, оношлох сорил шинжилгээнд дээж авсан дүгнэлтийн хуудас.

Аудитын явцад аймгийн ХХААГ-ын нэмэлт санхүүжилтийн дансны хуулга, гурвалсан гэрээ, санхүүжилт олгох хуваарь зэрэг анхан шатны баримт материалыг

тулган шалгаж үзэхэд дээрх журмын дагуу бүрдүүлсэн анхан шатны баримтыг үндэслэн 43 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн дансанд 328,570.6 мянган төгрөгийн санхүүжилтийг шилжүүлжээ.

Хэдийгээр МЭУСАХЗардлыг зориулалтын дагуу зарцуулсан ч анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой дараах алдаа, зөрчлүүд оршиж байна. Үүнд:

- ✓ *Санхүүжилт шилжүүлэх үндсэн баримт болох урьдчилан сэргийлэх тарилга, оношлох сорил шинжилгээнд дээж авсан дүгнэлтэд зарим эмч, мэргэжилтний гарын үсэг дутуу байлаа. 2015 онд 33 МЭҮН-д олгосон 264,863.7 мянган төгрөгийн санхүүжилтийн дүгнэлтэд 1-4 эмч, мэргэжилтний гарын үсэг зурагдаагүй байна. Энэ нь уг зардлыг зориулалт бусаар, дотоод хяналтгүй зарцуулах эрсдэлийг үүсгэж байна. /Хавсралт 3/.*
- ✓ *МЭҮН-үүдийн мал, амьтанд урьдчилан сэргийлэх тарилга хийсэн цувааны маягт бүрэн хөтлөгдөөгүй, мал сүрэгтээ тарилга хийлгэсэн малчны гарын үсэг дутуу, өрхийн эрүүл мэндийн дэвтрийн дугаарыг тэмдэглээгүй, малын болон вакцины тоо хэмжээг засварласан зэрэг зөрчил илэрлээ. 2015 онд 13 МЭҮН-ийн дүгнэлтийн хуудсанд нийт 31 малчин өрхийн 21.8 мянган толгой малд 1,736.2 мянган төгрөгийн тарилга хийлгэсэн малчин өрхийн эзний гарын үсэг зурагдаагүй байна. /Хавсралт 4/.*
- ✓ *“Эх жишиг” МЭҮН-д боомын вакцин хийсэн ажлын хөлсийг батлагдсан төсвөөс 388 толгой малаар хэтрүүлэн, 174.6 мянган төгрөгийн илүү санхүүжилт олгосон байна.*

Үүнээс гадна 12 мал эмнэлгийн үйлчилгээний нэгж гэрээгээр хүлээсэн 1-5 төрлийн 3,002.1 мянган төгрөгийн вакциныг хийгээгүй, заримд нь вакцин хийснийг нотлох анхан шатны баримтгүй учир санхүүжилт олгоогүй байна. Тухайлбал “Батцэнгүүн”, “Мэргэн-Онош”, “Лхачинбу”, “Оюут сүрэг”, “Буянт таван эрдэнэ”, “Эх жишиг”, “Хараа түшээ”, “Бөхлөө хангай”, “Сэлэнгэ гранд”, “Сэлэнгэ буянхишиг” зэрэг 10 МЭҮН-д шаардлагатай вакциныг нийлүүлсэн боловч вакциныг бүрэн хийсэн эсэхийг нотлох анхан шатны баримтгүй, түүнд хяналт тавьж, хэрэгжилтийг тооцоогүй байна. /Хавсралт 5/.

Цаашид анхан шатны баримтыг зохих заавар журмын дагуу иж бүрэн бүрдүүлсний үндсэн дээр санхүүжилтийг олгож байх, олгосон вакциныг бүрэн хийж байгаа эсэхэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

2.3 Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг анхан шатны баримт материалыг үндэслэн ажил гүйлгээ гарсан тухай бүр бүртгээгүй, зарим МЭҮН-дэд төлөх өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Аймгийн ХХААГ-ын 2015 оны санхүүгийн тайланд мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын санхүүжилт, МЭҮН-үүдэд төлөх өглөгийг тусгасан ч Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, зааврын дагуу бүртгэл хөтлөөгүй байна.

Өөрөөр хэлбэл ажил гүйлгээ гарсан тухай бүрт, харилцагч байгууллага тус бүрээр тооцоо үүсгэн бүртгэл хөтлөөгүй бөөн дүнгээр шууд зардалд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат

дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Тайлант хугацаанд 42 МЭҮН-тэй үүссэн 213,540.8 мянган төгрөгийн өглөгөөс 11 МЭҮН-тэй үүссэн 66,703.5 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. **/Хавсралт 2/.**

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх “эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Цаашид мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний ажил гүйлгээг холбогдох стандарт, зааврын дагуу тооцоо үүсгэн бүртгэж, тооцооны үлдэгдлийг баталгаажуулж байх шаардлагатай байна.

Бүлэг 3

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах мал, амьтны тоог бууруулан төсөв батлагдаж байгаа нь өвчлөл гарах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

3.1 Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, халдварт өвчлөлийн тоо буурч байгаа ч вакцинд хамрагдах малын тоог бууруулсаар байгаа нь өвчлөл гарах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг дараах хууль, эрх зүйн акт, баримт бичгүүдээр зохицуулж байна. Үүнд:

- ✓ Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль¹,
- ✓ Улсын Их Хурлын 2014 оны 53 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын нийгэм эдийн засгийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 5-р зорилт “Уламжлалт мал аж ахуй, эрчимжсэн мал аж ахуйг дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ”,
- ✓ Улсын Их Хурлын 2010 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол мал үндэсний хөтөлбөр”-ийн 3 дугаар зорилт “Мал эмнэлгийн ажил, үйлчилгээг олон улсын жишигт хүргэж, малын эрүүл мэндийг баталгаажуулах замаар нийгмийн эрүүл мэндийг хамгаалах”,
- ✓ Аймгийн ИТХ-ын 2010 оны 75 дугаар тогтоолоор “УИХ-аас баталсан Монгол мал үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-д

¹ 5 дугаар зүйл. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага, 8 дугаар зүйл. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааны улсын хяналтын байгууллагын тогтолцоо, 13 дугаар зүйл. Иргэн, хуулийн этгээдийн эрх, 14 дүгээр зүйл. Иргэн, хуулийн этгээдийн үүрэг, 15 дугаар зүйл. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт.

тусгагдсан мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээтэй холбогдолтой 2 заалт².

- ✓ Аймгийн ИТХ-ын “Үйлчилгээний хөлсний жишиг үнэлгээ тогтоох тухай” 2012 оны 21 дугаар тогтоол.
- ✓ Аймгийн ИТХ-ын 2013 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1 дүгээр бүлгийн холбогдох заалтууд³.

Дээрх эрх зүйн актуудад тусгагдсан мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний бодлогыг хэрэгжүүлэхээр 2015 онд аймгийн ТЕЗ бөгөөд аймгийн Засаг дарга, салбарын сайд, аймгийн ХХААГ-ын даргын хооронд үр дүнгийн гэрээ байгуулан үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг 8-9 тайлангаар гарган 90-96 хувьтай дүгнүүлжээ.

Үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөнд мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээтэй холбогдолтой 4-19 ажил үйлчилгээг хэрэгжүүлэхээр тусгаснаас вакцинжуулалтад хамрагдсан малд сериомониторинг шинжилгээг хийх, үр дүнг тооцох, малын гоц халдварт, халдварт өвчний тандалт шинжилгээг хийж, эпидемологи судалгааг нарийвчлан тогтоох, өвчний бүртгэл, мэдээллийн чанарыг сайжруулах захиалга үндэслэлийг боловсронгуй болгох, вакцинжуулалтын үр дүнд сериомониторинг хийх ажлыг 3-4 суманд хийж хэвшүүлэх зэрэг ажлын төсөв, хөрөнгийн асуудал шийдэгдээгүйгээс дутуу хийгдсэн байна.

Аймгийн ХХААГ-аас вакцинжуулалтад хамрагдсан малд сериомониторинг шинжилгээг хийх, үр дүнг тооцох ажлыг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргад 29,214.9 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төсөл” хийж хүргүүлсэн ч шийдэгдээгүй байна.

Мөн мал эмнэлгийн анхан шатны нэгжийн үйл ажиллагааг дэмжих, стандартын шаардлагад нийцүүлэх, дэмжлэг үзүүлэх, боловсон хүчний хангалтыг сайжруулах “Нэг баг-нэг МЭҮН” гэсэн зорилт дэвшүүлэн ажил үйлчилгээний чанар хүртээмж, нэгдмэл үйл ажиллагааг сайжруулах төлөвлөгөөт ажил нь боловсон хүчний хангалт, МЭҮН-үүдийн ажиллах нөхцөл боломж хүндрэлтэй байгаагаас шалтгаалан хэрэгжээгүй байна.

Аймгийн хэмжээнд 43 МЭҮН, 2 цэргийн анги, “Гацуурт” ХХК-д нийт 26 их эмч, 34 бага эмч, 7 мал зүйч, 18 санитарч ажиллаж, 9.4 мянган малчин өрхөд үйлчилдэг бөгөөд нэг нэгжид дунджаар 31.7 мянган мал, нэг эмчид 24.3 мянган мал ногдож байна⁴.

² Монгол мал хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эхний ээлжинд авах арга хэмжээний төлөвлөгөөний 13 дахь “Гаднаас орж ирж байгаа малыг үзлэг шинжилгээнд хамруулан эрүүл эсэхийг нягталж байх” мөн 16 дахь “Мал сүргийг дархлаажуулах ажлыг лабораторийн түүвэр шинжилгээгээр тогтоож, мониторинг хийх замаар урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг тооцон, эмч нарын харуцлагаг өндөржүүлнэ” гэсэн ажлыг 2010 оноос хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

³ 1.1 Хөдөө аж ахуйн бодлого 1.1.13 “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, малын үржлийн албыг бэхжүүлнэ.

1.1.17 “Мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн эмч, мэргэжилтний мэргэшил, ур чадварыг дээшлүүлж, багаж, тоног төхөөрөмж, эм урвалжийн хангалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээний чанар, үр дүнг сайжруулан, мал, мах экспортлох нөхцлийг бүрдүүлнэ”.

⁴ Сэлэнгэ аймгийн нийгэм эдийн засгийн 2015 оны 12 сарын танилцуулгад малтай 9406 өрх, мал бүхий 5170 өрх, нийт 1,458,740.0 толгой мал бүртгэгдсэн байна.

Сэлэнгэ аймагт 17 сумын 56 багт 43 МЭҮН үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд “Нэг баг-нэг МЭҮН” зорилтыг хэрэгжүүлэхэд дээрх боловсон хүчний дутагдалтай байдал нөлөөлж байна.

Малын өвчлөл, урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын талаар:

Сүүлийн 4 жилээр мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд /тарилгад/ хамрагдсан малын тоог 2013 онтой харьцуулахад 32.9-188.5 мянган толгойгоор буюу 3.2-18.1 хувиар буурсан байна. **IXавсралт 6I**-д дэлгэрэнгүй байдлаар харуулав.

Хүснэгт 2.

д/д	Үзүүлэлт	Малын тоо /мян.тол/		2013 онтой харьцуулсан бууралт малын тоо мян.тол	2013 онтой харьцуулсан бууралтын хувь
		төлөвлөгөө	Гүйцэтгэл ХБГ		
1	2013 он	1,047.6	1,040.4	-	-
2	2014 он	989.4	1,007.5	32.9	3.2
3	2015 он	994.5	980.5	59.9	5.8
4	2016 он	851.9	851.9	188.5	18.1

2015 онд 1 халдварт өвчин бүртгэгдэж, 2016 оны 3-р улирал хүртэл аймгийн хэмжээнд ямар нэгэн халдварт өвчлөл гараагүй байсан боловч 10 сараас эхлэн өмнө нь бүртгэгдэж байгаагүй гоц халдварт **цэцэг өвчин** Орхон, Орхонтуул сумын 49 өрхийн 3582 хонинд илэрснээс, 3388 хонинд эмчилгээ хийж, 194-ийг устгасан бөгөөд нийт 480 өрхийн 161995 хонийг вакцинжуулалтад хамруулжээ.


Өвчлөл гарсан шалтгааныг эцэслэн тогтоогоогүй байгаа бөгөөд холбогдох мэргэжилтнүүд дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

- *Малын гоц халдварт шүлхий, цэцэг өвчин гарсан голомт бүхий Хэнтий аймгийн Дархан, Хэрлэн баян улаан, Говьсүмбэр аймгийн Сүмбэр, Төв аймгийн Баян, Баян жаргалан сумдад жилийн 4 улирал нутаглаж байгаад Орхонтуул суманд 6-8 сард нүүж ирсэн 11 өрх айлын хариуцлагагүй байдлаас шалтгаалан дээрх өвчин гарсан. Эдгээр өрх айлууд халдварт өвчний голомтот нутгаас шилжин ирэхдээ засаг захиргааны нэгждээ бүртгүүлээгүй, урьдчилан сэргийлэх үзлэг хийлгээгүй, мал сүргээ вакцинд хамруулаагүй байсан байна.*

Сүүлийн жилүүдэд мал, амьтны бүртгэлтэй өвчлөлийн тоо буурч байгаа ч энэ хэмжээгээр урьдчилан сэргийлэх вакцинд хамрагдах малын тоог бууруулж байгаа нь малын халдварт өвчин гарах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

УМЭҮГ-т бүртгэлтэй, Сэлэнгэ аймгийн эпизоотологийн зураглалд тэмдэглэлтэй, мал эмнэлгийн лабораториор оношлогдсон халдварт өвчний бүртгэлээс харахад 2008 онд хамгийн их буюу 13 суманд 13.3 мянган мал, амьтанд 7 төрлийн өвчлөл гарч байсан бол 2015 онд Баруунбүрэн суманд 1 үхэрт хорт салст

хатуурал өвчин бүртгэгдсэн байна. 2011-2015 онд гарсан халдварт өвчлөлийг графикаар харуулав.



Мөн сүүлийн 5 жилийн байдлаар гарсан халдварт өвчний төрлийг авч үзэхэд Баруунбүрэн, Сант, Баянгол, Орхонтуул, Алтанбулаг, Зүүнбүрэн, Сайхан, Ерөө зэрэг 8 суманд галзуу, шөвөг яр, гахайн мялзан, ДХХ, энтериобактериоз, цахлай, колибактериоз, хорт салст хатуурал зэрэг 8 төрлийн халдварт өвчин бүртгэгдсэн байна.

Хүснэгт 3.

Үзүүлэлтүүд	2011 он					2012 он					2013 он					2014 он					2015 он				
	Галзуу	Шөвөг	Гахайн	ДХХ	Энтериобактериоз	Цахлай	Колибактериоз	Хорт салст	Хатуурал	Устгасан	Галзуу	Шөвөг	Гахайн	ДХХ	Энтериобактериоз	Цахлай	Колибактериоз	Хорт салст	Хатуурал	Устгасан	Галзуу	Шөвөг	Гахайн	ДХХ	Энтериобактериоз
Галзуу /B052/ Баруунбүрэн, Сант	1	1			1	1	1		1																
Шөвөг яр /B082/ Баянгол, Орхонтуул, Алтанбулаг,Сант, Баруунбүрэн, Зүүнбүрэн	13	155		155		11	59		59		22	220	18	202											
Энтериобактериоз Сайхан, Алтанбулаг	1	25	1	23	1						1	2	2												
Цахлай Алтанбулаг, Сайхан, Сант, Ерөө	22	343		343							4	23		23		4	12		12						
ДХХ Баруунбүрэн											2	10	10												
Колибактериоз Баянгол											1	2	1	1											
Гахайн мялзан Баянгол																2	58	10	48						
Хорт салст хатуурал Баруунбүрэн																				1	1	1			
Дүн	37	524	1	521	2	12	60	0	59	1	30	257	31	226	0	6	70	10	12	48	1	1	1	0	0

Урьдчилан сэргийлэх вакцинжуулалт, дархлаажуулалтад эрсдэлтэй бүх малыг хамруулж чадахгүй байна. Нийт 16 төрлийн вакцин хийгдэхээс 8 төрлийн вакцинд эрсдэлтэй мал, амьтны 60-иас дээш хувийг, 8 төрлийн вакцинд 60 хүрэхгүй хувийг хамруулахаар төсөв батлагдаж ирдэг байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2015 онд 1,458.7 мянган толгой мал тоологдсон бөгөөд 290.5 мянган толгой нь бод мал байна. Үүнээс мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу 16 төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг давхардсан тоогоор 997.7 мянган мал, амьтанд хийжээ.

Аймгийн ХХААГ, МЭҮН-үүдээс тухайн нутаг дэвсгэрт харьяалагдах мал, амьтанд гарч болзошгүй халдварт өвчний эрсдэлийг урьдчилан тооцож давхардсан тоогоор 409.0 мянган бод, 1,130.5 мянган бог, 92.0 мянган амьтныг вакцинд хамруулахаар захиалга өгч, төсвийн төсөл хүргүүлсэн ч 38.8 хувиар бууруулан батлагдсан байна.

Хүснэгт 4.

Д/д	Өвчний төрөл	Вакцинд хамрагдсан мал, амьтны тоо						Нийт дүн тоогоор	Вакцинд хамрагдалт нийт малын тоотой харь %-иар		2015 онд тариулахаа р эрсдэл үнэлсэн малын тоо /төсвийн санал/	Вакцинд хамруулахаар батлагдсан малын тоог эрсдэл үнэлсэн малын тоотой харьцуулалт %
		Тэмээ	Бод /адуу үхэр/		Бог /хонь, ямаа/		амьтан		Бод	Бог		
	2015 оны жилийн эцсийн малын тоо	484.0	290,017.0	Үүнээс унага, даага, тугал, бяруу: 161376	1,168,239.0	Үүнээс төл мал: 482773	-	1,458,740.0	Бод	Бог		
1	Шөвөг яр					145,055.0		145,055.0		30.0	250,000.0	58.0
2	ДХХ				104,084.0			104,084.0		8.9	251,500.0	41.4
	Галзуу		2,400.0					2,400.0	0.8		20,000.0	31.2
3	Галзуу						8,507.0	8,507.0			15,000.0	
4	Колибактериоз				949.0			949.0		0.1	1,500.0	63.3
5	Мялзан						20,768.0	20,768.0			26,000.0	79.9
6	Дуут			134,845.0				134,845.0	83.6		100,000.0	134.8
	Боом		199,989.0					199,989.0	69.0		178,000.0	62.9
7	Боом				226,702.0			226,702.0		19.4	500,000.0	
8	ГЦХИБ						23,717.0	23,717.0			26,000.0	91.2
9	Сохор догол				60,192.0			60,192.0		5.2	100,000.0	60.2
10	Ёлом						6,299.0	6,299.0			25,000.0	25.2
	Цусан халдварт		43,931.0					43,931.0	15.1		71,000.0	62.2
11	Цусан халдварт					1,500.0		1,500.0		0.1	2,000.0	
12	Цусан халдварт ийлдэс		100.0					100.0	0.03		1,500.0	6.7
13	Бактерин			18,630.0				18,630.0	53.1		20,000.0	93.2
14	Энтериобактериоз										22,000.0	0.0
15	Цахлай /ЛДФ/										20,000.0	0.0
16	Боом ийлдэс										2,000.0	0.0
Дүн		-	246,420.0	153,475.0	393,427.0	145,055.0	59,291.0	997,668.0			1,631,500.0	61.2

Вакцинд хамрагдсан малын тоог нийт малын тоотой харьцуулж үзэхэд хамгийн их буюу дуут вакцинд нийт унага, даага, тугал, бярууны 83.6 хувь нь хамрагдсан хийсэн бол хамгийн бага буюу цусан ийлдэс, колибактериоз, бог малын цусан халдварт, галзуу зэрэг вакцинд нийт бог, бод малын 0.03-0.8 хувийг хамруулсан байна.

Мөн вакцинд хамрагдсан мал, амьтны тоог эрсдэл тооцсон, урьдчилан сэргийлэх вакцинд хамруулах шаардлагатай мал, амьтны тоотой харьцуулж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Унага, даага, тугал, бяруунд хийх дуут вакцинд хамрагдах малын тоог захиалсан эрсдэл бүхий малын тооноос 34.8 хувиар илүү баталж ирүүлснээс вакцинд хамрагдалт 134 хувьтай,
- Унага, дааганд хийх сахуу, гахайд хийх цусан халдварт иж балнад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 91.2-93.2 хувьтай,
- Бод мал, нохойд хийх галзуу, цусан халдварт ийлдэс, бог малд хийх дотрын халдварт халуун, гахайд хийх ёлом зэрэг халдварт өвчний вакцин 6.7-41.4 хувьтай,
- Бод, бог малд хийх цусан халдварт, боом, бог малд хийх шөвөг яр, сохор догол, колибактериоз, амьтанд хийх мялзан зэрэг халдварт өвчний вакцинд 58.0-79.9 хувьтай тус тус хамрагджээ.

Харин бог малд хийх энтериобактериоз, боомын ийлдэс, бод малд хийх цахлай зэрэг халдварт өвчнөөс сэргийлэх вакциныг нийт 44.0 мянган малд хийхээр захиалсан ч батлагдаж ирээгүй байна.

Засгийн газрын “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт хийгдэж байгаа бөгөөд адуунаас бусад мал сүргийн охин төлийг толгой дараалан уг вакцинд хамруулахаар 2015 онд аймгийн Засаг даргын А/347 дугаар захирамж гарч ХХААГ-аас тарилгын хуваарь гарган баталжээ.

Аймгийн хэмжээнд адуунаас бусад 396.2 мянган охин төлд бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хийхээр төлөвлөснөөс 395.9 мянгыг буюу 99.9 хувийг хамруулсан байна. Уг вакцинд хамрагдах малын төлөвлөгөөг эхний хагас жилийн малын тоог үндэслэн хийдэг учир гүйцэтгэл 0.1 хувиар дутуу тайлагнагдсан байна.

Хэдийгээр аймгийн Засаг даргын захирамж, ХХААГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөнд бруцеллёзын вакцины үр дүнд мониторинг хийхээр тусгагдсан ч төсөв хөрөнгө шийдвэрлэгдээгүйгээс шалтгаалан 2015 онд хийгдсэн уг вакцины үр дүн, дархлаажуулалтын түвшинг тогтоож чадаагүй байна.

Вакцины чанар байдал, хугацаандаа нийлүүлэгдэж буй эсэх талаар МЭҮН-ийн эмч, мэргэжилтнүүдээс асуулга, тодруулга авахад дараах тайлбарыг өгч байлаа. Үүнд:

- ✓ Цусан халдвартын вакцины чанар муу, шимэгдэхдээ удаан байдаг бол бусад вакцины чанар сайн байдгаас малын ямар нэгэн халдварт өвчин гарахгүй байна.
- ✓ Зарим вакцин хугацаандаа ирдээгүй. 2015 онд боомын вакцин 4-5 сард хийх графикт хугацаатай ч 6 сард, ДХХ-н вакцин 4 сард хийгдэх ёстой ч 7 сард ирсэн тохиолдол гарч байсан байна.

Лабораторийн шинжилгээний талаар:

Лабораторийн шинжилгээ нь нийт төлөвлөсөн хэмжээгээр хийгдэж байгаа ч зарим МЭҮН-д технологт хугацаанд мал, амьтны цуснаас дээж авч аймгийн ХХААГ-ын лабораторт ирүүлээгүй байна.

МЭҮН-үүд мал, амьтны цусны дээжийг технологт хугацаанд ирүүлдэггүйгээс төлөвлөсөн санхүүжилтээ авч чаддаггүй байна. Тухайлбал 2015 онд Марс нуга, Туяа сан, Буянттаван эрдэнэ, Бадаанзүрх, Эх жишиг, Баян ишгэнт гэх мэт МЭҮН-үүд технологт хугацаандаа лабораторийн шинжилгээ хийлгэсэн акт ирүүлээгүй байна.

Аймгийн ХХААГ-аас технологт хугацаандаа шинжилгээний дээж ирүүлээгүй, хугацаа хоцроосон МЭҮН-үүдэд гурвалсан гэрээ болон санхүүжилт олгох журмын дагуу санхүүжилтийг олгоогүй байна.

Паразит өвчнөөс эмчлэн сэргийлэх /угаалга, туулгалт, боловсруулалт/, ариутгал халдваргүйтлийн ажлын талаар:

Малчин иргэдэд мал сүргээ халдварт болон паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх, ариутгал халдваргүйтэл хийлгэх ач холбогдоллыг ухуулан сурталчлах, тэдний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Мал, амьтны паразиттах өвчин нь тухайн бүс нутгийн онцлог, цаг улиралтай холбогдон халдварлан тархах зам харилцан адилгүй, өвчин тус бүрийн үүсгэгч, түүнийг халдварлуулан дамжуулагч, завсрын эзэн, үржих орчин нөхцөл гэсэн тодорхой цаг хугацаа, үе шатаар богино хугацаанд олон малд дамжин халдварладаг онцлогтой бөгөөд халдварласан нөхцөлд нийгэм, эдийн засагт онц хохирол учруулдаг ажээ.

Паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх угаалга, туулгалт, боловсруулалт хийх арга хэмжээнд 1,249.0 мянган толгой мал, амьтныг хамруулахаар төлөвлөснөөс давхардсан тоогоор 2,554.4 мянган толгой мал, амьтныг хамруулжээ.

Хүснэгт 5.

д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө мян.тол	Гүйцэтгэл мян.тол
1	Угаалга	534.0	1,097.8
2	Туулгалт	469.0	960.9
3	Боловсруулалт	246.0	495.7
Нийт дүн		1,249.0	2,554.4

Хэдийгээр нийт мал сүргийн 85.6 хувийг паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулахаар төлөвлөж 87.6 орчим хувийг хамруулж байгаа ч угаалга, туулгалт, боловсруулалтыг хийж байгаа МЭҮН-үүдэд хүндрэл ихээр гардаг байна.

Паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар МЭҮН-ийн эмч, мэргэжилтнүүдээс асуулга, тодруулга авахад дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

- ✓ *Угаалга, туулгалт, боловсруулалтын ажлын үйлчилгээний хөлсийг малчдаас авахаар зохицуулагдсан байдаг боловч үйлчилгээний хөлс төлөхдөө хойрго ханддаг, зарим нь хийлгэхгүй гэдэг тул МЭҮН-үүд гарсан зардлаа нөхөж чадахгүйд хүрдэг.*
- ✓ *Паразитийн төрлийн өвчний өргөн хэрэглээний эм тариаг МЭҮН-үүдээр дамжуулан, стандарт шаардлагын дагуу хийлгэдэггүй, малчид өөрсдөө дур мэдэн худалдан авч хэрэглэдэг байна. Тухайлбал ивомек тарилгыг эмчийн хяналтгүйгээр худалдан авч хийдэг бөгөөд энэ нь тухайн малын махаар дамжин ард иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, өвчлөх эрсдэлийг үүсгэдэг байна.*

2015 онд Алтанбулаг, Ерөө, Зүүнбүрэн, Орхонтуул, Орхон, Хушаат зэрэг 6 сумын 43 голомтын 2.7 мянган толгой малд 8 төрлийн паразиттах өвчин /ширх, хамуу, стронгилятоз, монезиоз, эргүү, диктокаулёз, хачиг, гемонхоз/ илэрсэн байна.

Мөн 2015 онд малын хашаа, гахай, шувууны байр, бэлтгэх газар, агуулах, зоорь, тоног хэрэгсэл, бэлчээрийн зэрэг нийт 1,560.0 мянган м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийхээр төлөвлөж 5,627.1 мянган м2 талбайд буюу 3.6 дахин их талбайг хамруулжээ.

Аймгийн ХХААГ, сумдын ХААТ, аймгийн МХГ-ын тайлан, мэдээнээс харахад МЭҮН, эмч, мэргэжилтнүүдэд хандсан сургалт, семинарийг зохион байгуулж байгаа ч малчин өрх, иргэдийг хамруулсан, тэдний эрх, үүргийг таниулсан сургалт төдийлөн зохион байгуулагдаагүй байна.

Аймгийн ХХААГ-аас ХААИС-ийн Мал эмнэлгийн багш нартай хамтран Алтанбулаг, Шаамар, Сүхбаатар сумдад өдөрлөг зохион байгуулж 200 орчим иргэнийг хамруулсан, МХГ-аас хяналт шалгалтын хүрээндээ 120 орчим иргэнд хандсан зөвлөмж, материал тарааснаас бусдаар мал бүхий иргэдэд хууль сурталчлах, тэдний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр ажил зохион байгуулаагүй байна.

Цаашид малчин өрхөд өөрийн өмч хөрөнгө болох мал сүргийг эрүүл байлгах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний ач холбогдол, тэдний үүрэг, хариуцлагыг сайжруулах чиглэлээр төрийн байгууллагууд хамтран ажиллах нь зүйтэй юм.

3.2 Хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож ажиллаагүй байна.

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулинд⁵ малын эрүүл мэндийг хагаалах үйл ажиллагааны хяналтыг мэргэжлийн хяналтын алба хэрэгжүүлэхээр заажээ.

Аймгийн МХГ-аас 2 жилд нэг удаа хяналт шалгалт хийдэг бөгөөд 2015 онд 4 МЭҮН-д, 2016 онд 14 МЭҮН-ийн эрсдэлийг **дунд гэж** үнэлэн 8 сумыг хамруулан хяналт шалгалт хийсэн бол ХХААГ-ын Захиргаа, удирдлагын хэлтсээс 2 сумын 4 МЭҮН-ийг хамруулан дотоод хяналт хийсэн байна.

2015 онд аймгийн МХГ-аас мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэлтэй холбоотойгоор 6 удаагийн хяналт шалгалт, тандалтын ажил хийж 1 аж ахуйн нэгжид албан шаардлага, 3 аж ахуйн нэгжид зөвлөмж хүргүүлж, холбогдох байгууллагуудад тайлан, судалгааг хүргүүлсэн байна. Албан шаардлагыг хэрэгжүүлэн ажилласан ч мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээтэй холбогдолтой дараах алдаа зөрчлийг арилгуулахаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг⁶ тооцоогүй байна. Үүнд:

- ✓ *Мал эмнэлгийн дуудлага, үзүүлсэн дуудлагын анхан шатны бүртгэлийг бүрэн хөтлөөгүй, шилжилт хөдөлгөөний судалгаагүй, баримт материалыг архивын тухай хуулийн дагуу архивын нэгж үүсгэн хадгалаагүй,*
- ✓ *Ариутгал халдваргүйжүүлэлтийн акт үйлдээгүй, бүртгэл хөтлөөгүй,*
- ✓ *Эм бэлдмэл, вакциныг тээвэрлэх, хадгалах, зарцуулах үйл ажиллагааг зааврын дагуу хийгээгүй, тарилгын акт, жагсаалтыг тогтмол хөтөлж хэвшээгүй,*
- ✓ *Мал эмнэлгийн ажил үйлчилгээг эрхлэх үйл ажиллагааны ойрын болон хэтийн бизнес төлөвлөгөөгүй,*
- ✓ *Малын гоц халдварт, халдварт, халдваргүй болон паразиттах өвчний тархвар зүйн бүртгэл, зураглалгүй, мэдээллийн санд баяжуулалт хийдээгүй,*
- ✓ *Оношлогоо, дээж авахдаа батлагдсан маягтыг ашигладаггүй, протокол үйлддэггүй,*
- ✓ *Хийдэг шинжилгээ тус бүрийн заавар, стандартад заасан тоног төхөөрөмж, багж хэрэгсэл, урвалж бодисоор бүрэн хангагдаагүй, шинжилгээний бүртгэл хөтлөгдөөгүй,*
- ✓ *Ажлын байрны нөхцөл хангагдаагүй,*

Улсын ерөнхий байцаагчийн 2015 оны 01/01 дугаар албан даалгаврын дагуу Аймгийн МХГ-аас мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн ХХААГ, мал бүхий иргэд, мал аж ахуй эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийг хамруулан хийж гүйцэтгэжээ. Үүний дүнд малчин өрхүүдэд “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль”-ийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгч, урьдчилан сэргийлэх тарилгыг төлөвлөсөн хугацаанд нь татан авч, МЭҮН-дэд олгож байх дүгнэлт гарсан байна.

МХГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө, МХЕГ-ын даргын баталсан 01/69 дугаар удирдамжийн дагуу аймгийн хэмжээнд мал, амьтны халдварт /боом, галзуу,

⁵ 8.1. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааны хяналтыг улсын хэмжээнд мэргэжлийн хяналтын төв байгууллага, орон нутагт мэргэжлийн хяналтын алба хэрэгжүүлнэ.

⁶ “Таван хишиг”, “Баатартүмэн сүрэг” МЭҮН, Цөм сүрэг ХХК-д өгсөн зөвлөмж.

шүлхий/ өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын хүрээнд вакцины тээвэрлэлт, хадгалалт, хамгаалалт болон тарилгын хүйтэн хэлхээний нөхцөл хангагдаж буй эсэхэд тандалт судалгаа хийсэн байна. Тандалтын үр дүнд дараах дүгнэлт гарсан байна. Үүнд:

- ✓ *Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй МЭҮН-ийн агуулахад хэлхээний хөргүүр байхгүйн улмаас вакцины чанар аюулгүй байдал алдагдаж байна,*
- ✓ *Вакцины тоо хэмжээ буурч өвчний голомттой бүсийн мал сүргийг бүрэн хамруулж чадахгүй байгаа нь өвчлөл гарах эрсдэлтэй байна.*

Аймгийн ХХААГ-ын Захиргаа, удирдлагын хэлтсээс газрын даргын баталсан удирдамжийн дагуу Алтанбулаг, Баянгол сумын 4 МЭҮН-ийн үйл ажиллагаанд дүгнэлт өгч, 6 малчин өрхийн “Өрхийн эрүүл мэндийн дэвтэр”-ийн хөтлөлт, ашиглалтыг үзсэн байна.

Дотоод хяналтаар МЭҮН-үүдийн баримт бичиг эмх цэгц муутай, архивын тухай хуулийн дагуу баримт материалаа үдээгүй, зарим айл өрхийн “Өрхийн эрүүл мэндийн дэвтэр”-т тэмдэглэл хөтлөгдөөгүй зэрэг дутагдалтай асуудлыг засаж залруулах зөвлөмж өгчээ.

2015 оны 11-р сард ХХААЯ-аас 3-р улирлын байдлаар аймгийн ХХААГ-ын үр дүнгийн гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийж “Мал аж ахуйн салбарын чиглэл”-ийн биелэлтийг 70 хувиар үнэлсэн байна.

Илэрсэн зөрчил

Хийж гүйцэтгэсэн аудитын дүнд илэрсэн дараах 336,480.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. *Эх жишиг МЭҮН-д боомын вакцины хөлсийг гэрээнд батлагдсан хуваарь, гэрээнд заасан дүнгээс 174.6 мянган төгрөгөөр илүү бодож олгосон.*
2. *12 МЭҮН 1-5 төрлийн 3,002.1 мянган төгрөгийн вакциныг хийгээгүй, заримд нь вакцинаа нийлүүлсэн ч хийсэн эсэхийг нотлох баримтгүй, хэрэгжилтэд хяналт тавиагүй.*
3. *13 МЭҮН-ийн дүгнэлтийн хуудсанд нийт 31 малчин өрхийн 21.8 мянган толгой малд 1,736.2 мянган төгрөгийн тарилга хийлгэсэн малчин өрхийн эзний гарын үсэг зурагдаагүй.*
4. *33 МЭҮН-д олгосон 264,863.7 мянган төгрөгийн санхүүжилтийн дүгнэлтэд 1-4 эмч, мэргэжилтний гарын үсэг зурагдаагүй.*
5. *Санхүүгийн тайланд тусгасан 11 МЭҮН-тэй үүссэн 66,703.5 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.*

Дүгнэлт

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүн, үр нөлөөнд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. *МЭҮН, ХХААГ-аас халдварт өвчлөлийн эпизоотологийн зураглал, өвчлөлийн бүртгэл зэргийг үндэслэн эрсдэлтэй бүх мал сүргийг урьдчилан*

сэргийлэх арга хэмжээнд хамруулахаар тооцож төсвийн төсөл хүргүүлдэг ч 41 хүртэлх хувиар бууруулан батлагджээ.

2. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг батлагдсан төсвийн хүрээнд, зориулалтын дагуу зарцуулж байгаа ч анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаагүй ажил гүйлгээг бүртгэлд тусгаж байна.
3. Малын урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын санхүүжилтийг аймгийн төсвөөс олгосон санхүүжилтийн хэмжээ, ажлын гүйцэтгэлд үндэслэхгүйгээр МЭҮН-дэд харилцан адилгүй олгож байна.
4. Мал эмнэлэгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах мал, амьтны тоо буурч байгаа нь өвчлөл гарах эрсдэлийг нэмэгдүүлж байна.
5. Малчин өрх, иргэдэд чиглэсэн малын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг, боловсрол олгох, хариуцлагыг дээшлүүлэх сургалт, ухуулан таниулах арга хэмжээ хангалтгүй байна.
6. Малчид паразитийн төрлийн өвчний өргөн хэрэглээний эм тариаг МЭҮН-үүдээр дамжуулан, стандарт шаардлагын дагуу хийлгээгүйгээр өөрсдөө дур мэдэн худалдан авч хэрэглэж байна.
7. Малчид ивомек тарилгыг эмчийн хяналтгүйгээр худалдан авч хийдэг бөгөөд энэ нь тухайн малын махаар дамжин ард иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, өвчлөх эрсдэлийг үүсгэж байна.

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Засаг дарга Ш.Оргилд:

1. МЭҮН-үүдийн үйл ажиллагааг хэвийн явуулж, малын урьдчилан сэргийлэх арга хэмжээг дэмжих санхүүжилтийг бүрэн олгож байх.
2. Малчин иргэдэд мал сүргээ халдварт болон паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх, ариутгал халдваргүйтэл хийлгэх ач холбогдолыг ухуулан сурталчлах, тэдний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авах.
3. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүн, зардлын төлөвлөлт, гүйцэтгэл, хөрөнгийн зарцуулалтад дотоод аудит хийж, үр дүнг үнэлж байх.

Аймгийн ХХААГ-ын дарга Б.Мөнхтөрд:

1. Мал эмнэлэгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг үнэлж, хуваарилах аргачлалыг боловсруулж, батлуулан мөрдөх.
2. Санхүүжилтийн үндэслэл болох анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангах, холбогдох анхан шатны баримтыг иж бүрэн бүрдүүлсний үндсэн дээр санхүүжилт олгох.
3. МЭҮН-ийн санхүүжилтийг харилцан адилгүй олгож буй зөрчлийг арилгаж, аймгийн төсвөөс олгосон санхүүжилтийн хувь хэмжээ, МЭҮН-үүдийн ажлын гүйцэтгэлд нь үндэслэн жигд олгож байх.

4. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний орлого, зарлагын бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн стандарт, зааврын дагуу бодитой бүртгэж байх.
5. Вакциныг хугацаанд нь нийлүүлж байхад анхаарч ажиллах.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР
ШИНЖЭЭЧ

Ч.ЭНХТУЯА
Б.БАТМӨНХ
Б.ЭРДЭНЭЗУЛ
А.ДАШБАТ